



МОНГОЛ УЛСЫН  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ  
THE JUDICIAL GENERAL COUNCIL OF MONGOLIA

# МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ЦАХИМЖИЛТЫН ЯВЦ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ БА ХИЙДЭЛ



2025 он



МОНГОЛ УЛСЫН  
ШҮҮХИЙН ЕРӨНХҮЙ ЗӨВЛӨЛ  
THE JUDICIAL GENERAL COUNCIL OF MONGOLIA

# МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ЦАХИМЖИЛТЫН ЯВЦ, ХҮҮЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ БА ХИЙДЭЛ



2025 он

# АГУУЛГА

01

**Удиртгал**

1.1

Үндэслэл

1.2

Шүүхийн цахимжилттай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт

1.3

Монгол Улсын шүүхийн цахимжилтын хөгжлийн явц

1.4

Цахим шүүх 2.0

02

**Цахимжилтын явц**

2.1

Суурь бэлтгэл ажил

2.2

Системийн хөгжүүлэлт суурилуулалт

2.3

Хэрэгжүүлэх нэвтрүүлэх

03

**Гарах үр дүн, дүгнэлт**



МОНГОЛ УЛСЫН  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ  
THE JUDICIAL GENERAL COUNCIL OF MONGOLIA



# Удиртгал



# Үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д “Төр цахим хэлбэрт шилжсэнээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран Төрийн үйлчилгээ шат дамжлагагүй, шуурхай болно” гэж заасан бөгөөд уг баримт бичгийн 5 дахь зорилгын Засаглал хэсэгт “Хариуцлагатай, иргэн төвтэй шүүхийг төлөвшүүлэх” гэж тусгасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын шүүхийн эрх мэдлийн хөгжлийн бодлого”-д “Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө”; “Шүүх эрх мэдлийн байгууллагын цахим үйлчилгээний үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, иргэд цахимаар үйлчлүүлэх нөхцөлийг үе шаттайгаар бүрдүүлнэ” гэж мөн зорилт 3.1-д “Шүүхийн үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлж, шуурхай, чирэгдэлгүй болгоно”; “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахимжсан тогтолцоо, эрх зүйн орчныг үе шаттайгаар бүрдүүлнэ” гэж тус тус тусгасан.

Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.11 дэх заалтын дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого” батлах, хэрэгжүүлэх мөн 71.1.12 дахь заалтын дагуу “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэл, хяналтын нэгдсэн систем, цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулах программ хангамжийг хөгжүүлэх, хэвийн ажиллагааг хангах гэж;

Шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.11 дэх заалтын дагуу дараах ажлууд хийгдсэн нь шүүхийн цахимжилтыг шинээр бий болгох, технологийн шинэчлэл хийх үндэслэл болсон:

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах тухай” 322 дугаар тогтоол;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Шүүхийн цахим шийдлийн энтерпрайз архитектур, техник эдийн засгийн үндэслэлийг батлах тухай” 44 дүгээр тогтоол;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Шүүхийн цахим шийдлийн энтерпрайз архитектур, техник эдийн засгийн үндэслэлийн зөөлөн дэд бүтцийг боловсруулж, нэвтрүүлэх ажлын даалгавар батлах тухай” 105 дугаар тогтоол.



# Монгол Улсын шүүхийн цахимжилттай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт

## Шүүхийн тухай хууль:

Энэ хуульд заасан "Шүүхийн цахим платформ" гэж шүүхийн үйл ажиллагаанд мэдээлэл цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон түүний аюулгүй байдлыг хангах зорилго бүхий үндсэн программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн системийг хэлнэ." гэж тодорхойлсон. Шүүхийн тухай хуульд цахимжилттай холбоотой дараахь заалтууд орсон. Үүнд:

71.1.Ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан байдлыг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

71.1.11.шүүхийн Тамгын газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх;

71.1.12.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэл, хяналтын нэгдсэн систем, цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулах программ хангамжийг хөгжүүлэх, хэвийн ажиллагааг хангах;

71.1.14.шүүх хуралдааны дууны, дуу-дүрсний бичлэг хийх, архивлах болон шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журмыг хуульд заасны дагуу батлах;

71.1.27.цахимаар хийсэн худалдаа, цахим орчинд хийсэн гэрээ, хэлцэл, интернэт үйлчилгээ, интернэт орчинд анх удаа хэвлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн талаар маргаан, интернэтэд нийтлэгдсэн буюу түгээсэн бүтээлийн зохиогчийн эрх буюу бусад холбоотой эрхийг зөрчсөнтэй холбоотой маргаан, интернэтийн домэйн нэр, эзэмшил, түүний зөрчилтэй холбоотой маргааныг тухайлан хуульд заасан тохиолдолд цахим шүүхээр шийдвэрлэх платформ, эсхүл шүүх хуралдааныг цахимаар хэрэгжүүлэх программ хангамжийг хөгжүүлэх;

"71.1.28.шүүхээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах цахим платформ, программ хангамж, техникийн шаардлагыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны холбогдох хуульд нийцүүлэн тодорхойлох, нэвтрүүлэх, хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангах;

71.1.29.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөлжсөн цахим мэдээллийн санг нийтийн мэдээллийн дэд бүтэцтэй уялдуулан бүрдүүлэх;

12.16.Шүүхийн үйл ажиллагааг дараах байдлаар хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчид цахимаар нээлттэй, ил тод байлгана:

12.16.1.хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нараас шүүхийн цахим платформд нэвтэрч, иргэний болон захиргааны хэргийн материал, талуудын гаргасан гомдол, нэхэмжлэл, хүсэлт, түүнд холбогдох нотлох баримт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн захирамж, шийдвэртэй цахимаар танилцах боломжийг хангах, хуульд заасан мэдээллийн системээр дамжуулан мэдээлэл, баримт бичиг хүлээн авах, хүргүүлэх, харилцах боломжийг бүрдүүлэх;

71.1.30.хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;

12.16.2.зөрчил шалган шийдвэрлэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагааны явцад хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нараас гаргасан хүсэлт, гомдлын шийдвэрлэлт, шүүх, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнаас гаргасан шийдвэр, тогтоол, захирамж, шинжээчийн дүгнэлт, хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт болон хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн ажиллагааны явцтай цахимаар танилцах боломжийг хангах, хуульд заасан мэдээллийн системээр дамжуулан мэдээлэл, баримт бичиг хүлээн авах, хүргэх, харилцах боломжийг бүрдүүлэх";

Цахимжилттай холбоотой бусад заалтууд: 12.2.2, 12.2.3, 12.3, 12.14, 12.15, 22.8.

## Монгол Улсын шүүхийн цахимжилттай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт

Монгол улсын шүүхийн тухай хууль, хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд хуулийн зохицуулалтаас үзэхэд Монгол Улсад шүүхийн цахимжуулалт, тэр дундаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим хэлбэрээр хэрэгжүүлэх, эхлүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж үзэх үндэслэлтэй байна. Дараахь хуулиудад нэмэлт өөрчлөлт орсон:



Шүүхийн тухай хууль:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай

Зөрчил шалган шийдвэрлэх тухай

Дээрх зохицуулалтаас үзэхэд Монгол Улсад шүүхийн цахимжуулалт, тэр дундаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим хэлбэрээр хэрэгжүүлэх, эхлүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчин бүрэн бүрджээ. Мэдээж хөгжлийг дагаж шинээр бий болж байгаа харилцааг зохицуулах, одоо байгаа зохицуулалтыг илүү тодорхой болгох зайлшгүй шаардлагууд урган гарна.

## Монгол Улсын шүүхийн цахимжилтын хөгжлийн явц

Монгол Улсын шүүхийн цахимжилтын хөгжлийг үндсэн хоёр шатанд хувааж үзэж болох бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн “Цахимжилтын нэршил тогтоох тухай” 230 дугаар тогтоолоор дараах нэршлийг өгөхөөр тогтсон. Үүнд:

- Шүүхийн үйл ажиллагаанд 2024 он хүртэлх хугацаанд нэвтрүүлсэн системийн бүх бүрдлийг “Цахим шүүх 1.0” гэж;
- 2025 оноос шинээр нэвтрүүлэх шүүхийн цахим шийдлийн энтерпрайз архитектурын зөөлөн дэд бүтцийн цахим системийн бүрдлийг “Цахим шүүх 2.0” гэж, цахим хаягийг “e-court.mn” гэж нэршүүлэхээр тус тус тогтоосон.


Монгол Улсын шүүхийн мэдээллийн технологийн түүх эхэлсэн 1994 оноос хойш 2024 он хүртэл программ хангамж, техник хангамж, мэдээллийн аюулгүй байдал, өгөгдөл солилцооны үсрэнгүй хөгжлийг бий болгосон хэдий ч мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийн өнөө үед шүүхийн цахим шийдэлд үүлэн технологи, блокчэйн, хиймэл оюун ухаан, машины тооцоолол, виртуал орчин дэмжих, и-пэй (e-pay), цахим төлбөр тооцооны системийн хөгжүүлэлт хийх зэрэг олон улсын дэвшилтэт, сүүлийн үеийн технологийн шийдэл бүхий өгөгдөл солилцооны интеграци бий болгох зайлшгүй шаардлага урган гарсан.



# “Цахим шүүх” 1.0


Шүүхийн цахимжилт (1994-2024)

2013




Захиргааны  
хэргийн  
бүртгэл,  
хяналтын  
нэгдсэн  
систем

2014



Иргэний хэрэг  
шүүхэд хянан  
шийдвэрлэх  
“Иргэн-2014”  
нэгдсэн систем

2017



Эрүүгийн  
хэргийн  
бүртгэл,  
хяналтын  
нэгдсэн систем

## ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНД:

1. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “Иргэн-2014” нэгдсэн систем
2. Захиргааны хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем
3. Эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем
4. Эвлэрүүлэн зуучлалын систем
5. Иргэдийн төлөөлөгчийн систем
6. Эрэн сурвалжлах, албадан ирүүлэх бүртгэлийн систем
7. “Гэрэгэ” систем /төлбөрийн систем/
8. Шүүхийн цахим лавлагааны систем /ХУР/
9. [www.live.shuukh.mn](http://www.live.shuukh.mn) Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим систем
10. [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) Шүүхийн шийдвэрийн цахим сан

## ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД:

1. Хэргийн хөдөлгөөний удирдлагын төвийн систем
2. Хэргийн хөдөлгөөний удирдлагын “E-Case” систем
3. Шүүгчийн сонгон шалгаруулалтын систем
4. Шүүхийн цахим архивын систем
5. Тамгын газрын мэдээллийн сан
6. Хүний нөөцийн систем
7. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн “ERP” систем
8. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас
9. [www.judcouncil.mn](http://www.judcouncil.mn) цахим хуудас
10. [www.judges.shuukh.mn](http://www.judges.shuukh.mn) Нийт шүүгчийн чуулганы цахим хуудас

# Цахим шүүх 2.0

## Зорилго

Цахим шүүхийн тогтолцоог шүүх эрх мэдлийн өргөн хүрээний зорилтуудтай стратегийн хувьд уялдуулж, үр ашигтай, хүртээмжтэй, ил тод, аюулгүй байдлыг хангах хүрээнд шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх дэвшилтэт технологи бүхий зөөлөн дэд бүтцийг бий болгоход оршино.

## Зорилтууд

**Цахим шүүхийн системийн үндсэн зорилтууд болох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр ашиг, ил тод байдал, хүртээмжийг сайжруулах зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тодорхойлсон.**

**Үр ашгийг дээшлүүлэх:** Хэргийг шийдвэрлэх хугацааг бууруулахын тулд шүүхийн үйл ажиллагааг оновчтой болгоно. Мөн түүнчлэн цаг хугацаа хүний нөөц их шаарддаг ердийн ажлуудыг автоматжуулах;

**Хүртээмжтэй байдлыг сайжруулах:** Хэргийн мэдээлэл, бичиг баримт бүрдүүлэх, виртуал шүүх хуралдаанд зайнаас оролцох зэрэг шүүхийн үйлчилгээг олон нийтэд илүү хүртээмжтэй болгох;

**Ил тод байдал, хариуцлага:** Шүүхийн тогтолцоонд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхийн тулд шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрийн ил тод байдлыг нэмэгдүүлэх;

**Датад тулгуурласан шийдвэр гаргах:** Бодлогын шийдвэр гаргах, шүүхийн удирдлагыг сайжруулахын тулд мэдээллийн аналитикийг ашиглах;

**Интеграцлал ба харилцан уялдаатай ажиллах чадвар:** Цахим шүүхийн систем нь хууль сахиулах, хорих анги, захиргааны байгууллага зэрэг төрийн бусад системтэй саадгүй харилцах боломжийг хангах;

**Аюулгүй байдал ба нууцлал:** Хэргийн нууц материалыг агуулсан мэдээллийг хамгаалж, төрийн, албаны болон хувь хүний мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийг дагаж мөрдөх;

**Өргөтгөх чадвар:** Өсөн нэмэгдэж буй шүүхийн ачаалал, шинэ технологитой интеграци хийх гэх мэт эрэлт хэрэгцээг хангах, ирээдүйд хийх өргөтгөлүүдэд дасан зохицож чадах системийг бий болгох;

**Зардал хэмнэлттэй байдал:** Системийг зардал хэмнэлттэй хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын өгөөжийг сайн хангах;

**Хэрэглэгчийн сэтгэл ханамж:** Шүүгч, хуульч, шүүхийн ажилтнууд, олон нийт зэрэг бүх оролцогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн хэрэглэгчдэд хялбар, ойлгомжтой системийг бий болгох.



# Цахим шүүх 2.0

**Шүүх тогтолцооны өгөгдлийн цөм системийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны систем:** Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэхтэй хамааралтай үйл ажиллагаануудыг цахим хэлбэрээр хэрэгжүүлэх системийг бий болгох ажлын хүрээнд холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн Эрүүгийн, Иргэний, Захиргааны хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, өргөдөл хүлээн авах, эвлэрүүлэн зүүчлах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүгч болон шүүгчийн туслахын хувийн модуль болон бусад модуль боловсруулах ажлыг гүйцэтгэнэ

**Шүүх тогтолцооны өгөгдлийн цөм систем:** Шүүхийн цахим шийдлийн оролцогч талуудын үйл ажиллагааг нэгдсэн нэг хялбар загварт шилжүүлж, мэдээлэл бүртгэх, боловсруулах, дамжуулах, тайлагнахтай холбоотой үүссэн өгөгдлийг цөм системд хадгалж, хэрэглэгч талуудын ажиллагааг цахимжуулах үндсэн систем юм. Шүүхийн захиргааны албан хаагчид болон шүүгчийн ашиглах вэб хандалтад нэгдсэн систем байх бөгөөд суурь платфоомоос иргэд, олон нийтийн порталд тайлан илгээх, бусад төрийн байгууллагад мэдээлэл дамжуулах үүрэг бүхий шүүхийн цахим шийдлийн дундын удирдлагын систем байна

**Шүүхийн захиргааны үйл ажиллагааны систем:** Тамгын газруудын захиргааны үйл ажиллагаанд үйл явцуудыг дижитал буюу цахим хэлбэрт шилжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, үйл ажиллагаа, нэгжүүдийн уялдаа холбоог сайжруулах замаар нөөцүүдийг оновчтой төлөвлөх боломжийг бүрдүүлнэ. Эдгээр систем бүр нь шүүхийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг, захиргаанаас эхлээд шүүхийн үйл явц хүртэлх хэсгүүдийг хамрах бөгөөд хууль зүйн тогтолцоог илүү хүртээмжтэй, үр дүнтэй, ил тод болгох зорилготой



**Иргэд, олон нийтийн систем (Портал болон аппликэйшн):** Иргэд, олон нийт болон хэргийн оролцогчид тус технологийн дэд бүтцийн тусламжтайгаар шүүх тогтолцоотой холбоотой харилцаанд оролцдог систем. Иргэн төвтэй шүүхийн тогтолцоог бий болгоход хамгийн их үүрэг гүйцэтгэх систем бол иргэд олон нийтэд зориулсан аппликэйшн болон веб систем юм. Мөн иргэд, олон нийтийн системд ШЕЗ болон шүүхийн Тамгын газар бүрийн мэдээллийн цахим талбар байх ба хууль, дүрэм, журамд заасан нээлттэй байрлуулах мэдээллүүд, байгууллагын танилцуулга, бусад мэдээллийг үзэх боломжтой байна

**Шүүхийн цахим архив:** Шүүхийн тусгай архив болон салбар архивын хүлээн авсан хэргийн баримт, түүнд холбогдох албан хэрэг хөтлөлтийн баримтыг бүртгэх, мэдээ тайлан гаргах, иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр лавлагаа, тодорхойлолтыг түргэн, шуурхай олгоход ашиглах мэдээлэл, лавлагааны нэгдсэн, цахим санг бий болгоно. Баримт бичгийн дижитал хувийг, тодорхойлон бичсэн бүтэцтэйгээр төрөлжүүлэн хадгалах, ашиглах, түгээх боломжтой технологийн дэд бүтэц юм

**Өгөгдөл солилцох дэд бүтэц:** Шүүх тогтолцооны цахим системүүд өөр хоорондоо болон бусад байгууллагуудын технологийн дэд бүтцүүдтэй өгөгдлийг электрон хэлбэрээр солилцох боломжтой систем;

**Дэмжих дэд бүтцүүдтэй интеграци хийх систем:** Бусад дэмжин ажиллах төрийн болон бусад байгууллагуудын үйл ажиллагааны тусдаа системүүдтэй харилцан холбогдон ажилладаг байна. Харилцан холболт хийж, бусад системээс өгөгдөл мэдээллийг оруулах болон нэгтгэсэн өгөгдлийг гаргаж авах боломжтой байна



МОНГОЛ УЛСЫН  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ  
THE JUDICIAL GENERAL COUNCIL OF MONGOLIA



ЦАХИМЖИЛТЫН ЯВЦ




# “Цахим шүүх” 2.0

Шүүхийн цахимжилтын үе шат



Суурь  
бэлтгэл  
ажил

I шат



Системийн  
хөгжүүлэлт  
суурилуулалт

II шат



Хэрэгжүүлэх  
нэвтрүүлэх

III шат

## Суурь бэлтгэл ажил

“Шүүхийн цахим платформ” буюу “Цахим шүүх 2.0” системийг бий болгох дараах суурь бэлтгэл ажлууд хийгдсэн. Үүнд:


- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Шүүхэд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах тухай” 322 дугаар тогтоол;
- 2024 оны Монгол улсын төсвийн тухай хуулийн “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”-ний ажилд “Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны суурь мэдээллийн систем, цөм систем”-ийг хийх төсөв тавигдсан;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Шүүхийн цахим шийдлийн энтерпрайз архитектур, техник эдийн засгийн үндэслэлийг батлах тухай” 44 дүгээр тогтоол;
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Шүүхийн цахим шийдлийн энтерпрайз архитектур, техник эдийн засгийн үндэслэлийн зөөлөн дэд бүтцийг боловсруулж, нэвтрүүлэх ажлын даалгавар батлах тухай” 105 дугаар тогтоол;
- Монгол Улсын Их хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар Шүүхийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудын нэмэлт өөрчлөлтөөр цахимжилттай холбоотой заалтууд шинээр орсон;
- “Шүүхийн цахим шийдлийн энтерпрайз архитектур, техник эдийн засгийн үндэслэлийн зөөлөн дэд бүтцийг боловсруулж, нэвтрүүлэх ажлын даалгавар”-ын дагуу 2024 оны 8 сард гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж гэрээ хийсэн;

# Бэлтгэл ажил – Хатуу дэд бүтэц, мэдээллийн аюулгүй байдал болон бусад

Шүүхийн цахимжуулалтын хатуу дэд бүтэц, мэдээллийн аюулгүй байдал болон бусад бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.  
Үүнд:

- Дэд бүтцийн бэлэн байдлыг хангахтай холбоотой сүлжээний анализ, эмзэг байдлын шинжилгээ, кибер аюулгүй байдлын эрсдэлийн шинжилгээ, мэргэжлийн байгууллагаар сүлжээний аудит хийсэн;
- Дэд бүтцийн аудитын дагуу сайжруулалтыг хийх, дотоод сүлжээний архитектурыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах, шүүхийн захиргааны байгууллагуудын дамжуулах сүлжээний бэлэн байдлыг хангах, хатуу, зөөлөн дэд бүтэц болон мэдээллээ найдвартай байршуулах серверийн өрөөг дахин шинэчлэл хийх, дэд бүтцийн тэжээлийн эх үүсвэр, нөөц цахилгаан тэжээл болон хөргөлтийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, цахим систем хэрэглэгч талуудад болон хэрэглэгчдэд дэмжлэг тусламж үзүүлэх “Call center” нэвтрүүлэх ажлуудыг үе шаттай хийж байна;
- Байгууллагын хэмжээнд мөрдөгдөх эрх зүйн баримт бичгүүдийн ангилал, ашиглах хамрах хүрээ, оролцогч талууд болон тэдгээрийн эрх үүрэг, ажиллах дараалал, ашиглалт, хяналт зэргийг тодорхойлсон эрх зүйн баримт бичигтэй ажиллах журмыг шинэчлэн гаргах. Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 стандарт нэвтрүүлэх, процессын ре-инженерчлэл хийх ажлууд хийгдэж байна;
- Цахим системийн хэрэгжүүлэлтийг дэмжих бодлогын хүрээнд мэдээлэл технологийн цахим системийн тасралтгүй үйл ажиллагааг хариуцахтай холбоотой орон тоог нэмэгдүүлэн шинэчлэн зохион байгуулах, тогтвортой ажиллуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, төслийг амжилттай нэвтрүүлэх зорилгоор хугацаат төслийн нэгжийг байгуулах, ажилтнуудын цахим үр чадварыг дээшлүүлэхтэй холбоотой сургалтад тогтмол хамруулж, гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулах, хүний нөөцийн зохицуулалт, илүү цагийн хөлс, ажлын ачаалалд онцгой дэмжлэг үзүүлэх гэх мэт ажлуудыг хийсэн;
- Цаашид мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо буюу ISO/IEC 27001:2022-ыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

# I шат: Суурь бэлтгэл хангах





## II шат: Системийн хөгжүүлэлт, суурилуулалт

Шүүхийн цахим шийдлийн энтерпрайз архитектур, зөөлөн дэд бүтцийг бий болгох



Дэд бүтцийн бэлэн байдлыг хангахтай холбоотой ажлыг мэргэжлийн байгууллагаар сүлжээний аудит хийлгэх

Дэд бүтцийн бэлэн байдлыг хангах, цахим системийн хэвийн үйл ажиллагааг дэмжих

Чанарын удирдлагын тогтолцоог бий болгох

Шүүхийн цахим системийн үйл ажиллагааны стандартыг тогтоох

Цахим системийн хэрэгжүүлэлтийг дэмжих бодлогын хүрээнд хийх ажлууд

Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог бий болгох

# ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ ЯВЦ

| Үе шат / Систем |                       | Суурь платформ | ХХША-ны систем | ИОН портал, апп | Шүүхийн цахим архив | Өгөгдөл солилцох дэд бүтэц | Шүүхийн ERP систем |
|-----------------|-----------------------|----------------|----------------|-----------------|---------------------|----------------------------|--------------------|
| Хөгжүүлэлт      | Шаардлага тодорхойлох | ✓              | ✓              | ✓               | ✓                   | ✓                          | ✓                  |
|                 | UI/UX дизайн          | ✓              | ✓              | ✓               | ✓                   | ✓                          | ✓                  |
|                 | Back-end хөгжүүлэлт   | ✓              | ✓              | ✓               | ✓                   | ✓                          | ✓                  |
|                 | Front-end хөгжүүлэлт  | ✓              | ✓              | ✓               | ✓                   | ✓                          | ✓                  |
|                 | Сайжруулалт           | ↻              | ↻              | ↻               | ↻                   | ✓                          | ↻                  |
| Чанар, МАБ тест | UAT тест              | ✓              | ✓              | ✓               | ✓                   | ✓                          | ✓                  |
|                 | Функциональ тест      | ✓              | ✓              | 🕒               | 🕒                   | ✓                          | ✓                  |
|                 | Ачааллын тест         | 🕒              | 🕒              | 🕒               | 🕒                   | ✓                          | ✓                  |
|                 | Эх кодын шалгалт      | ✓              | ✓              | ✓               | ✓                   | ✓                          | ✓                  |
|                 | Дэд бүтцийн шалгалт   | ✓              | ✓              | ✓               | ✓                   | ✓                          | ✓                  |
|                 | Нэвтрэлтийн шалгалт   | ✓              | ✓              | ✓               | ✓                   | ✓                          | ✓                  |
| Нэвтрүүлэлт     | Гарын авлага          | ↻              | ↻              | ↻               | ↻                   | ✓                          | ✓                  |
|                 | Сургалт               | 🕒              | 🕒              | 🕒               | 🕒                   | ↻                          | ↻                  |




✓ Хийгдсэн

↻ Хийгдэж буй

🕒 Хүлээгдэж буй

# ЕСР.Е-COURT /ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМ/

| Шүүх                                                                                   | Систем                                        | Хэрэг                          | ХХШҮА                                                        | Wire-frame | Хуулийн баг | Дэд ажлын хэсэг | Хөгжүүлэлт | Хэрэглэгч тест | Сайжруулалт |
|----------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------|--------------------------------|--------------------------------------------------------------|------------|-------------|-----------------|------------|----------------|-------------|
| ДҮҮРГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХЯЛБАР АЖИЛЛАГААНЫ АНХАН ШАТНЫ ТОЙРГИЙН ШҮҮХИЙН ХҮРЭЭНД | Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны систем | Эрүүгийн хэрэг                 | Тусгайлан журмаар ХХША (75.1)                                | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | ТСАХ (14)                                                    | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Зөрчил                                                       | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               | Иргэн, олон нийтийн портал ВЕБ | ТСАХ                                                         | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Зөрчил                                                       | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Тусгайлан журмаар ХХША                                       | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        | Иргэн, олон нийтийн АПП                       | Эрүүгийн хэрэг                 | ТСАХ                                                         | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Зөрчил                                                       | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Тусгайлан журмаар ХХША                                       | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               | Иргэний хэрэг                  | Онцгой ажиллагааны журам                                     | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Ердийн журмаар хянан шийдэх                                  | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Тусгайлан журм                                               | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
| НИЙТ ШҮҮХИЙН ХҮРЭЭНД                                                                   | Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны систем | ИХХША                          | Хялбаршуулсан журам (74)                                     | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Эвлэрүүлэн зуучлал                                           | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Давж заалдах журмаар ХХША                                    | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Хяналтын журмаар ХХША                                        | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Тусгай журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа              | ✓          | ✓           | ✓               | ✓          |                | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Ердийн журмаар хянан шийдэх                                  | ✓          | ✓           | ✓               | ✓          |                | ✓           |
|                                                                                        |                                               | ЭХХША                          | Хялбаршуулсан журам (74)                                     | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Захиргааны хэргийн зөрчлийн журам                            | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Давж заалдах журмаар ХХША                                    | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Хяналтын журмаар ХХША                                        | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               | ЭХХША                          | Албадлагын арга хэмжээ ЭЧААХ                                 | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Хялбаршуулсан журмаар ХХША                                   | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Ердийн журмаар ХХША                                          | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид холбогдох (18.1) | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Давж заалдах журмаар ХХША                                    | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        |                                               |                                | Хяналтын журмаар ХХША                                        | ✓          | ✓           | ✓               | ✓          |                |             |
|                                                                                        | Иргэн, олон нийтийн систем                    | Веб                            | Бүртгүүлэх                                                   | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Нэвтрэх                                                      | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Нэхэмжлэл - Онцгой журам                                     | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Хэрэг                                                        | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Шүүх хуралдаан тов баталгаажуулах                            | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Тэмдэгтийн хураамж тооцоолуур                                | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               | Апп                            | Статистик мэдээ                                              | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Бүртгүүлэх                                                   | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Нэвтрэх                                                      | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Нэхэмжлэл - Онцгой журам                                     | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Хэрэг                                                        | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |
|                                                                                        |                                               |                                | Шүүх хуралдаан тов баталгаажуулах                            | ✓          | ✓           | ✓               | ✓          | ✓              | ✓           |



### Таслан сэргийлэх арга хэмжээ

Бүтээсэн  
1

Хоцорч буй  
62

Хүлээгдэж буй  
21

Шийдвэрлэсэн  
1

Нийт  
85

Бүртгэлийн дугаараар хайх  
Энд хайлт хийх

Эрүүгийн хэргийн дугаараар хайх  
Энд хайлт хийх

Шийдвэрийн дугаараар хайх  
Энд хайлт хийх

Саналын төрөл  
Бүгд

Төлөв  
Бүгд

Эхлэх огноо  
Огноо сонгох

Дуусах огноо  
Огноо сонгох

Татах

Г

÷






| № | ТСАХ-ний дугаар  | Шийдвэрийн дугаар | ТСАХ-ын төрөл                                                            | Хэргийн дугаар | Хүлээн авсан огноо | Системд бүртгэсэн | Шийдвэрлэх гуагуша             | Төлөв         | Үйлдэл |
|---|------------------|-------------------|--------------------------------------------------------------------------|----------------|--------------------|-------------------|--------------------------------|---------------|--------|
| 1 | 316/TC/2025/0261 |                   | Тодорхой үйл ажиллагааг мөрдүүлж, албан үүргээ биелүүлэхийг тууштай хийх | 03940393       | 2025/04/23         | 2025/04/28 17:14  | 2025-05-01 2 өдөр 23 цаг үлдээ | Хүлээгдэж буй | ⊗      |
| 2 | 316/TC/2025/0260 |                   | Цагдааг хорих                                                            | 531212341234   | 2025/04/23         | 2025/04/28 17:14  | 2025-04-29 23 цаг үлдээ        | Хүлээгдэж буй | ⊗      |
| 3 | 316/TC/2025/0259 |                   | Тодорхой үйл ажиллагааг мөрдүүлж, албан үүргээ биелүүлэхийг тууштай хийх | 03940393       | 2025/04/23         | 2025/04/28 17:14  | 2025-05-01 2 өдөр 23 цаг үлдээ | Хүлээгдэж буй | ⊗      |
| 4 | 316/TC/2025/0258 |                   | Цагдааг хорих                                                            | 531212341234   | 2025/04/23         | 2025/04/28 17:14  | 2025-04-29 23 цаг үлдээ        | Хүлээгдэж буй | ⊗      |

ТСАХ бүртгэх

Хэргийн статистик

Шүүлийн нөхцөл


Хэргийн жагсаалт



# СИСТЕМ ДЭЭР ХИЙГДСЭН ДАШБОАРД: ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭ



СИСТЕМ ДЭЭР ХИЙГДСЭН ДАШБОАРД: ШҮҮГЧИЙН ЗОХИСТ АЧААЛЛЫН ШИНЖИЛГЭЭ



# ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМ

Байгууллагын дотоод үйл ажиллагаа, нөөцийн удирдлага хяналтын үйл ажиллагаануудыг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжийг бүрдүүлсэн цогц ERP систем.

- |                              |                                       |
|------------------------------|---------------------------------------|
| 1. Хүний нөөц                | 13. Тайлангийн удирдлага              |
| 2. Албан бичиг               | 14. Хууль эрх зүй                     |
| 3. Цаг бүртгэл               | 15. Цахим хуудасны удирдлага          |
| 4. Тушаал шийдвэр            | 16. Хэвлэл мэдээллийн бүртгэл, хяналт |
| 5. Хурал                     | 17. Захиалга                          |
| 6. Гүйцэтгэлийн төлөвлөгөө   | 18. Тамгын газрын архив               |
| 7. Гэрээний хяналт           | 19. Үнэлгээ                           |
| 8. Ажил хэрэг                | 20. Төсвийн төлөвлөлт                 |
| 9. Захидал                   | 21. Худалдан авалт                    |
| 10. Харилцагч                | 22. Санхүү                            |
| 11. Хяналт шинжилгээ үнэлгээ | 23. Хэргийн хөдөлгөөний мониторинг    |
| 12. Төсөл хөтөлбөр           |                                       |





# ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СИСТЕМИЙН НЭВТРҮҮЛЭЛТИЙН ЯВЦ

| Үе шат | Системууд                                                                                                                                                                                                                                                                                                                  | Хөгжүүлэлт | Тест | Сайжруулалт | Сургалт | Интеграци | Зүгшрүүлэлт |
|--------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------|------|-------------|---------|-----------|-------------|
| I      | 1. Хүний нөөц (10 дэд модуль)<br>2. Албан хэрэг хөтлөлт (2 дэд модуль)<br>3. Гэрээний хяналт<br>4. Байгууллагын архив<br>5. Ажил төлөвлөлт (2 дэд модуль)<br>6. Хурлын удирдлага<br>7. Цахим хуудасны агуулгын удирдлага<br>8. Хэргийн хөдөлгөөний статистик<br>9. Захидал<br>10. Харилцагч<br>11. Үнэлгээ<br>12. Захиалга | ✓          | ✓    | ✓           | ✓       | ✓         | ✓           |
| II     | 1. Хяналт, шинжилгээ, үнэлгээ<br>2. Төсөл хөтөлбөр<br>3. Тайлангын удирдлага<br>4. Хууль эрх зүй<br>5. Хэвлэл мэдээллийн бүртгэл, хяналт                                                                                                                                                                                   | ✓          | ✓    | ✓           | ✓       | ✓         | ✓           |
| III    | 1. Санхүү<br>2. Төсвийн төлөвлөлт<br>3. Худалдан авалт                                                                                                                                                                                                                                                                     | ✓          | ✓    | ✓           | ✓       | ✓         | ✓           |



Хийгдсэн




Хийгдэж буй





Хүлээгдэж буй

# Дэмжих дэд бүтцүүдийн интеграци



## Ажлын даалгаврын дагуу хийгдэх AI-ийн сервисүүд



# Хиймэл оюун ухааны чиглэлээр хийгдэх ажлууд

“Цахим шүүх 2.0” системд хиймэл оюун ухаантай холбоотой дараах ажлууд хийгдэнэ. Үүнд:

## Хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны системийн шүүгч болон шүүгчийн туслахын модуль:

- Шүүхийн шийдвэрийн сан болон эрх зүйн зохицуулалтын сангаас хайлт, шүүлт хийх үйл ажиллагаанд хиймэл оюун ухааныг ашигладаг байх;

## Шүүхийн шийдвэрийн сан:

- Шүүхийн шийдвэрийн санг нийтлэхдээ хиймэл оюун ухааныг ашиглах хувь хүний болон байгууллагын мэдээллийг нууцлан, автоматжуулан хэрэглэхэд хялбар байлгана;
- Шүүхийн шийдвэрийн санд 400 мянга гаруй шүүхийн шийдвэрийн сангаас төсөөтэй хэргийн шийдвэрүүдийг шүүлт хийж харуулахдаа хиймэл оюун ухааныг ашиглана;

## Тайлангийн үндсэн шаардлага:

- Төрийн албаны албан бичиг, бусад солилцоо болон шүүхийн шийдвэр, хуралдааны тэмдэглэл гэх мэт бүхий бичиг баримт үйгуржин монгол бичигт хөрвөх боломжтой байх;

## Бусад системүүдтэй холбогдох ерөнхий шаардлага:

- Voice to Text болон Text to Voice технологийг ашиглан шүүх хуралдааны үед яригдсан дууг текст болгон хөрвүүлэх;
- Текстын үг үсгийн алдаа систем өөрөө шалгадаг байна;
- Бичлэгийг өндөр нарийвчлалтай таних боломжтой байх, ба эргэлзээтэй үгнүүдийг монгол хэлний үгийн сангаас ижил төстэй үгийн хувилбараар санал болгодог байна (Энэ үйлдлийг хийхдээ хиймэл оюунаар сургаж гүйцэтгүүлдэг байж болно);

## Цахим архивын модулийн функциональ шаардлага:

Цахимжуулан оруулсан баримтын төрлөө автоматаар таних, сонгосон газраас түлхүүр үг таних, тухайн баримт бичиг дээр бүх текстийг таньж хадгалах боломжтой байна;

# III шат: Хэрэгжүүлж нэвтрүүлэх

1. Цөм систем
2. ХХШҮАС – Хялбар ажиллагаа
  - Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны шүүх
3. Захиргааны ERP – 41 Тамгын газар
  1. Хүний нөөц
  2. Албан бичиг
  3. Цаг бүртгэл
  4. Тушаал шийдвэр
  5. Хурал
  6. Гүйцэтгэлийн төлөвлөгөө
  7. Гэрээний хяналт
  8. Ажил хэрэг
  9. Захидал
  10. Харилцагч
  11. Хэргийн хөдөлгөөний удирдлага мониторинг
  12. Статистик тайлан
4. Шүүхийн цахим архив
5. Өгөгдөл солилцооны систем
6. Удирдлагын хяналтын самбар
7. Олон нийтэд зориулсан цахим хуудас

1. Цөм систем
2. ХХШҮАС - ЗХХША
  - Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх
  - Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх
  - Хяналтын шатны шүүх
3. Захиргааны ERP  
Хяналт шинжилгээ үнэлгээ  
Төсөл хөтөлбөр  
Тайлангийн удирдлага  
Хууль эрх зүй  
Цахим хуудасны удирдлага  
Хэвлэл мэдээллийн бүртгэл, хяналт  
Захиалга  
Тамгын газрын архив  
Үнэлгээ
4. Шүүхийн цахим архив
6. Удирдлагын хяналтын самбар
7. Олон нийтэд зориулсан цахим хуудас  
Гар утасны аппликейшн

➢ Чанар тест  
➢ Мэдээлэл аюулгүй байдлын тест  
➢ Сургалт

➢ Чанар тест  
➢ Мэдээлэл аюулгүй байдлын тест  
➢ Сургалт

➢ Чанар тест  
➢ Мэдээлэл аюулгүй байдлын тест  
➢ Сургалт

1. Цөм систем
2. ХХШҮАС – ИХХША
  - Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх
  - Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
  - Төв аймаг дахь сум дундын анхан шатны шүүх
  - Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
  - Хяналтын шатны шүүх
3. Захиргааны ERP  
Төсвийн төлөвлөлт  
Худалдан авалт  
Санхүү
4. Шүүхийн цахим архив - ИХХША
6. Удирдлагын хяналтын самбар
7. Олон нийтэд зориулсан цахим хуудас  
Гар утасны аппликейшн

1. Цөм систем
2. ХХШҮАС – ЭХХША
  - Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх
  - Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх
  - Төв аймаг дахь сум дундын анхан шатны шүүх
  - Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
  - Хяналтын шатны шүүх
3. Захиргааны ERP
  1. Хэргийн хөдөлгөөний удирдлага мониторинг
  2. Статистик тайлан
4. Шүүхийн цахим архив - ИХХША
6. Удирдлагын хяналтын самбар

## Гарах үр дүн

Монгол Улс шүүхийн цахим тогтолцоог үе шаттайгаар хөгжүүлж байгаа нь эерэг үзүүлэлт хэдий ч хууль эрх зүйн зохицуулалтыг зөвхөн шүүхийн тогтолцоогоор хаязгаарлахгүй бүхэлд нь төрийн үйл ажиллагааг эхлэхээс дуусгавар болж архивын цахим баримт болон хадгалагдах хүртэл тодорхой болгож, хэрэгжүүлэх, түүнтэй уялдсан иргэдийн дижитал оролцооны түвшинг нэмэгдүүлэх шаардлага байсаар байна. Цаашид олон улсын сайн туршлагыг судалж, өөрийн нөхцөлд нийцүүлэн хууль, практикийг уялдуулан хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой.

Шүүхийн үйл ажиллагааны цахимжилт нь зөвхөн үйл ажиллагааг хялбаршуулахаас гадна **хууль эрх зүйн давхардал, хийдэл, зөрчилдөөнийг илрүүлэх, бууруулахад** дараах байдлаар үр дүнтэй. Тухайлбал,

- **Ил тод байдал нэмэгдэнэ:**

- Шүүхийн шийдвэрүүд хүний хувийн мэдээллийг хамгаалах болон холбогдох бусад хуульд заасан нөхцлийг ханган цахим санд байршдаг болсноор хууль хэрэглэх практик илүү нээлттэй болно;
- Иргэн шүүхийн үйлчилгээг хялбар, шуурхай авдаг болно;
- Өмгөөлөгч, судлаачид хууль хэрэглээний нэгдмэл байдалд дүн шинжилгээ хийх боломжтой болно.

- **Хуулийн давхардал, хийдэл, зөрчил илүү хурдан илэрнэ:**

- Хэрэв тодорхой маргааны талаар шүүхүүд өөр өөрөөр тайлбарлаж, шийдвэр гаргаж байвал энэ нь тухайн асуудлаар хуульд хийдэл байгаа гэсэн дохио байх боломжтойг илрүүлнэ;
- Ийм мэдээллийг хууль тогтоогч (УИХ) болон эрх бүхий байгууллага судлан үзэж, хуулийг шинэчлэх, сайжруулах үндэслэл болно. Төрийн бодлого хуулиар илрэн гарч, хэрэгжиж байдаг.

- **Авлига, бусад нөлөөлөл багасна:**

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесс бүхэлдээ цахимжсан (жишээ нь хэрэг хуваарилалт автомат болох) нь хүний оролцоог багасгаж, аливаа нөлөөлөл, шударга бус байдлын эрсдэлийг бууруулна.

# Дүгнэлт

Цаашид шүүхийн цахимжилтыг хэрэгжүүлэхийн тулд хууль **эрх зүйн орчныг сайжруулах, тодорхой болгох** дараах чиглэлүүд байна.

Үүнд:

- Хиймэл оюуныг хэрхэн хэрэглэх, хэрэгжүүлэхтэй холбоотой хууль эрх зүйн зохицуулалт одоогоор байхгүй байгаа нь эрх зүйн бүрэн хийдэл бий болгох боломжтой.
- Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2-д заасан “Шүүх хуралдааныг нээлттэй явуулах, шүүхийн цахим хуудас, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсхүл олон нийтийн цахим сүлжээгээр энэ хууль болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухайлсан хуульд заасны дагуу шууд дамжуулах, эсхүл олон нийтэд дуу-дүрсний бичлэгээр хүргэх” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13, 16.17-д заасан хувь хүний нууцыг хуулиар тогтоож хамгаалах, хүний үндсэн эрхийг зөрчсөн зөрчил бий болгох нөхцлийг бүрдүүлжээ. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11, 4.1.12, 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан хүний хувийн мэдээлэл, хүний эмзэг мэдээллийг төрийн байгууллага болон бусад этгээд цуглуулах, боловсруулах, ашиглах талаар зохицуулалт, мэдээллийн эзний зөвшөөрөлтэйгөөр дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг заалтууд Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрхэд халдах нөхцөлийг бий болгож, шүүх хуралдааныг түүний зөвшөөрөлгүй шууд дамжуулах, байршуулахаар зохицуулагджээ. Энэхүү зөрчилдөөн нь эрх зүйн бүрэн хийдлийг бий болгож байна гэж үзнэ. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилсөн хууль нь хуулийн хэрэглээний эрэмбийн хувьд зөрчил бус, харин эрх зүйн онолын хувьд бүрэн хийдэл буюу зохицуулалтгүй байдалд тооцогдоно.
- Шүүхийн цахимжилтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд төрийн бусад байгууллагуудтай хамтын ажиллагаа, мэдээллийн уялдаа холбоо зайлшгүй шаардлагатай. Үүнийг төрийн бодлого, манлайлалын түвшинд хийх нэгдсэн шийдэл, зохицуулалт шаардлагатай.

Эцэст нь, УИХ-с хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах хууль эрх зүйн орчинг богино хугацаанд бүрдүүлсэн нь сайшаалтай. Хууль эрх зүйн орчин бүрдсэн боломжийг бүрэн ашиглаж, цахим шүүхийн бодит үр өгөөжийг иргэд, оролцогч талуудад хүртээмжтэй, аюулгүй, хурдтай болгох нөхцөл бүрдүүлэн хэрэгжүүлэхийн тулд хүний хувийн мэдээллийг хамгаалах ба ил тод байдлын заагийг нэг мөр болгох, кибер аюулгүй байдал, нэгдсэн архив, байгууллагуудын уялдаа холбоо, интеграци зэрэг нарийн түвшний асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна.





МОНГОЛ УЛСЫН  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ  
THE JUDICIAL GENERAL COUNCIL OF MONGOLIA

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА

